


ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/16-2023/01/20

ТОП 20 индекс



МХБ-ын Топ 20 индекс өнгөрсөн долоон хоногт 38,036 нэгжид хүрч өнгөрсөн 7 хоногоос 1.79%-иар өссөн байна. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 6.89 их наяд ₮ хүрээд байна.

Өнгөрсөн долоон хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 74 компанийн 2.8 тэрбум ₮-ийн 9.78 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан ба арилжааны дүн 33%-иар өссөн байна.

Үүнээс 271.7 сая ₮-ийн ХБҮЦ, 217 сая ₮-ийн компанийн бонд, 290.6 сая ₮-ийн хамтын хөрөнгө оруулалтын сан, 2.04 тэрбум ₮-ийн хувьцааны арилжаа хийгдсэн байна.

ХАМГИЙН ИХ ДҮНГЭЭР АРИЛЖИГДСАН

Монголын хөрөнгийн Бирж	730,818,138
АПУ	239,713,774
Голомт Банк	154,940,867
Тавантолгой	134,203,105
Ард санхүүгийн нэгдэл	124,187,559

ХАМГИЙН ИХ ӨСӨЛТТЭЙ

	Үнийн дүн	Өсөлт
Евро Азия Капитал	5,866	31.52%
Тавантолгой	134,203,105	26.98%
Жуулчин дюти фрий	731,400	16.26%
Баянгол Зочид Буудал	915,000	15.00%
Тэнгэрлиг медиа групп	1,435,800	12.83%

ХАМГИЙН ИХ БУУРАЛТТАЙ

	Үнийн дүн	Бууралт
Оллоо	83,438	-25.79%
Эрдэнэс сольюшинс	4,033,410	-23.08%
Багануур	1,387,053	-18.04%
Тав	830,000	-16.67%
Э-Транс Ложистикс	97,500	-15.56%

Хамгийн их дүнгээр арилжаалагдсан 5 хувьцаа өнгөрсөн 7 хоногийн хувьцааны хоёрдогч арилжааны 68%-ийг эзэлж байна. Өнгөрсөн долоон хоногт 2022 оны сүүлийн долоон хоногт IPO хийсэн Монголын хөрөнгийн бирж ХК хамгийн их дүнгээр арилжаалагдсан байна. Тус үнэт цаас нь IPO хийснээсээ хойш хөрвөх чадвар өндөр байна.

Өнгөрсөн долоон хоногт Евро Азия Капитал Холдинг ХК 31.52%-ийн өсөлт үзүүлсэн боловч арилжааны дүн харьцангуй бага байна. Мөн Тавантолгой ХК 26.98%-ийн өсөлт үзүүлсэн ба тус компани нь 2022 оны хагас жилийн тайлангаараа ашгийн өндөр өсөлт үзүүлсэн билээ.

Өнгөрсөн 7 хоногт Оллоо ХК хамгийн өндөр хувь хэмжээгээр буюу 25.79%-ийн уналт үзүүлсэн байна. Үнийн дүнгийн хувьд мөн харьцангуй бага байна.


Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/16-2023/01/20

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индексийн багц шинэчлэгдлээ
2022 оны үзүүлэлтээр ТОП-20 индексийн багцыг шинэчлэхэд өмнөх багцад багтаж байсан 15 компани хэвээр үлдэж Мах импекс, Би Ди Сек, Дархан Нэхий, Талх Чихэр, ЛэндМН ХК-иуд хасагдаж шинээр Төрийн банк, Голомт банк, Сэнтрал Экспресс Си Ви Эс, Богд Банк, Сэндли ББСБ ХК-иуд нэмэгдсэн байна.



“Эрдэнэт Суварга” ХК ногдол ашиг тараахаар боллоо

- “Эрдэнэт суварга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023/01/12-ны өдрийн хурлаар компанийн 2022 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5 төгрөгөөр тооцон ногдол ашиг тараахаар шийдвэрлэлээ.
Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2023/02/06-ны өдрөөр тасалбар болгон тогтоож, ногдол ашгийг 2023/06/30-ны өдрийн дотор ҮЦТХТ-р дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

+976 75100575

info@rhinosinvest.mn

www.rhinosinvest.mn

